

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
яамны 2025 оны есдүгээр сарын 13-ны
өдрийн 02 дугаар албан бичгийн хавсралт



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

**“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УЛСЫН ТӨСӨВТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР
2025 ОН

**“КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 01 сарын 15-ны өдөр

№4

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго,
үндэслэл, арга зүй**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд заасан яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэх, дүгнэх зорилт, арга хэмжээг тус тус үндэслэн тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, илэрсэн алдаа, дутагдлыг арилгах, цаашид үүсэж болзошгүй аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд гол зорилго оршино.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

“Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 19 арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа:

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн гүйцэтгэлтэй – 11 арга хэмжээ;
2. Гол үр дүн гарч ирж байгаа, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн гүйцэтгэлтэй -2 арга хэмжээ;
3. Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн гүйцэтгэлтэй – 4 арга хэмжээ;
4. Боловсруулалтын шатны арга хэмжээ хийгдсэн буюу 50%-ийн гүйцэтгэлтэй – 2 арга хэмжээ;
5. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30% гүйцэтгэлтэй – 0 арга хэмжээ;
6. Үр дүнгүй буюу 0% гүйцэтгэлтэй - 0 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арифметик дунджаар тооцож үзэхэд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт **“тодорхой үр дүнд хүрсэн”** буюу **87.3 хувь** буюу Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 4.5.2-т заасны дагуу **“хэвийн”** гэж үнэлэгдлээ.

Газрын 19 арга хэмжээг 8 стратегийн зорилтод хуваасан байдалд дүн шинжилгээ хийхэд дараах үр дүнтэй байна.

Хүснэгт 1. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын стратегийн зорилтод 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээг үнэлсэн нэгтгэл.

Д/д	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан стратеги төлөвлөгөөний зорилт	Арга хэмжээ тоо	Үнэлгээ
1	Захиргаа удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд	4	75%
2	Нийтийн төвийн гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг хангах.	2	100%
3	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дотоод сургалтын төлөвлөгөөг батлуулах, сургалтыг тухай бүр зохион байгуулахад нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	2	70%
4	Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээр хийлгэх хуулийн хэрэгжилтийг хангуулах	2	75%
5	Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах	1	100%
6	Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	1	100%
7	Кибер халдлага, зөрчлийн талаар судалгаа, дүн шинжилгээ хийх	3	53.3%
8	Кибер халдлагад хариу үзүүлэх	4	100%
Нийт		19	87.3%

Газрын 8 зорилт, 19 арга хэмжээний биелэлтэд дүн шинжилгээ, хийхэд дараах үр дүнтэй байна.

Дээрх 19 арга хэмжээнээс амжилттай хэрэгжсэн “Үр дүнтэй” буюу 100 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээг онцлон дурдвал:

✓ Гүйцэтгэлийн тайлангийн 4 дүгээр зорилт, Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч, зөвлөмж, шаардлага хүргүүлэх ажлыг ОЧМДББ болон хувийн хэвшлийн байгууллагуудад шаардлага, зөвлөмж хүргүүлж, нийт 8 (10.52%) байгууллагаас Мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайланг хүлээн авсан гэж тайлагнажээ.

✓ Гүйцэтгэлийн тайлангийн 5 дугаар зорилт, гүйцэтгэлийн тайлангийн 5.1 дэх арга хэмжээ болох мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшүүлэх сургалт зохион байгуулах мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагыг сонгон шалгаруулж бүртгэх, үйл ажиллагааг Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн төслийг ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологийн Сургуультай хамтран сургалтын хөтөлбөр батлуулсан, мөн “Цахимд зөв байя” аяны хүрээнд Захиалгат мэдээллийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр боловсруулсан гэж тайлагнажээ.

Түүнчлэн тус газрын 19 арга хэмжээнээс хэрэгжилтийн тайлан алдаатай, хүрэх түвшиндээ бүрэн хүрээгүй 50 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээг дурдвал:

✓ Гүйцэтгэлийн тайлангийн 1 дугаар зорилтын 1.2 дахь арга хэмжээ буюу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах” журмын 2.1-д заасны дагуу Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг журмын дагуу удирдах дээд байгууллагад хүргүүлэх арга хэмжээний биелэлтийг Захиргаа удирдлагын газар, Мэдээлэл дүн шинжилгээний газар, Кибер халдлагаас урьдчилан сэргийлэх газар, Кибер халдлагад хариу үзүүлэх газруудын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр тус тус баталсан гэж тайлагнажээ, тус

тайлан нь арга хэмжээний 2024 оны хүрэх түвшинд хүрээгүй, төлөвлөсөн арга хэмжээнд дурдагдсан ажлууд бүрэн хэрэгжээгүй байлаа.

✓ Гүйцэтгэлийн тайлангийн 4 дүгээр зорилтын 4.2 дахь арга хэмжээ буюу Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар мэдээлэл өгөх арга хэмжээний биелэлтийг Финтекийн зээлийн үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвшлийн компаниудыг оролцуулан FINSEC форум, 47 хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагуудын дунд уулзалт, кибер аюул заналаас урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээлэл хүргүүлсэн, "Кибер тусгаар тогтнол II" форумыг Кибер аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай хамтран зохион байгуулсан, мөн төр, иргэн, хувийн хэвшил хооронд харилцан мэдээлэл солилцож, аюулгүй байдлын хэм хэмжээ, стандарт тогтоон мөрдөх, кибер гэмт хэргээс сэргийлэхэд хамтран ажиллаж, мэдээллийн нууцлалтай, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг хангах арга замуудаа тодорхойлох үйл ажиллагааг зохион байгуулсан, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Интермед, Юнител, E-Clinic, Playmaker зэрэг 6 байгууллагуудын дарк веб дээрх мэдээллийг хайж, уулзалт, 5Хас банк болон "Бүрэн скор ЗМС" ХХК-дад хяналт-шалгалт хийж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч нийт 5 арга хэмжээг зохион байгуулсан ажилласан гэж тайлагнажээ, дээрх арга хэмжээ 2024 оны зорилтод түвшиндээ хүрээгүй 50 хувьтай биелсэн байлаа.

Мөн төлөвлөлт алдаатай, хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт болон зорилтод түвшин, тайлантайгаа уялдахгүй, хүрсэн үр дүнг тоон утгаар илэрхийлээгүй, шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинд туссан ажлуудыг дутуу тайлагнасан зэрэг шалтгаанаар үнэлгээг бууруулсан болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах явцад дараах зөрчлүүд илэрлээ. **Үүнд:**

1. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу боловсруулаагүй;

2. Төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгаж буй арга хэмжээнүүдийг суурь судалгаанд үндэслэн, салбарт тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай, үр дүнтэй ажил арга хэмжээнүүдийг эрэмбэлэн төлөвлөөгүй;

3. Төлөвлөгөөнд тусгагдсан зарим хэмжээний тайланг үр дүнд суурилж, хувь болон тоон утгаар оновчтой тайлагнаагүй;

4. Нэг арга хэмжээнд олон шалгуур үзүүлэлтүүд тусгасан, тайланг үнэлэхдээ шалгуур үзүүлэлтээр үнэлсэн боловч арга хэмжээ тус бүрээр үнэлээгүй;

5. Тайлагналтын алдаатай, хийж хэрэгжүүлсэн ажлаа товч, тодорхой, үр дүнтэй, тайлагнаж чадаагүй;

6. Гүйцэтгэлийн тайлангийн 1.4, 2.1, 4.2, 5.1 дэх арга хэмжээнүүдийн биелэлтийг тайлагнахдаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаагүй, гэх мэт алдаа дутагдлууд байлаа.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / зөвлөмж /

Хэрэгжилт хангалтгүй ажлуудыг эрчимжүүлэхэд анхааран, ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна. **Үүнд:**

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журам, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу боловсруулах;

2. Гүйцэтгэлийн тайланд “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувьтай үнэлэгдсэн 1.2, 4.2 дахь арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлд ажил зохион байгуулж, зорилтод түвшинг бүрэн хангуулах;

3. Яам болон байгууллагын стратеги төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичгүүдэд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хийж, хэрэгжүүлэхээр туссан зорилт, арга хэмжээнүүд болон салбартаа үр дүн гаргахуйц, томоохон ажил, ажил арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

4. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, тодорхой, ойлгомжтой, үр дүнд суурилсан бодит нотолгоотой тайлан бичиж ирүүлэх;

5. Байгууллагын төлөвлөгөө, тайланг зөв төлөвлөж, тайлагнах чиглэлд Удирдлагын академиас мэргэжлийн багш нарын багц сургалтыг авч, байгууллагын албан хаагчдын чадавхыг сайжруулан, үйл ажиллагаагаа сайжруулахад анхаарах;

Жич: “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрын, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт хяналт, шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийн биелэлтэд анхаарч ажиллан, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг журмын дагуу зөв боловсруулах, талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

-оОо-